



МҮХАҮТ

7 ХОНОГИЙН ТОЙМ



2026.04.27 – 2026.05.01

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Дугаар / 26.05

ГАДААД ТОМИЛОЛТ “SIAL” ҮЗЭСГЭЛЭН



БУСАД НҮҮРЭНД



Монреал дахь Өргөмжит Консул Пол Лэмитэй уулзалт хийлээ



Монгол-Канадын бизнесийн хамтын ажиллагааны шинэ гарцуудыг судаллаа



МҮХАҮТ, Канадын TFO байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлнэ



Канад улсад үйл ажиллагаа явуулж буй "CASHMERE CASA" дэлгүүртэй танилцлаа



Монголын хүнс үйлдвэрлэгчид Хойд Америкийн хамгийн том үзэсгэлэн "SIAL CANADA"-д оролцлоо



МҮХАҮТ болон Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага хамтын ажиллагааны уулзалт хийлээ



Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын тухай хуулийн шинэчлэл – бизнесийн орчинд юу өөрчлөгдөх вэ?



Хосмог сургалтыг танилцуулах, Төр-Хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх өдөрлөг амжилттай зохион байгуулагдлаа



7 ХОНОГИЙН ТОЙМ

Монреал дахь Өргөмжит Консул Пол Лэмитэй уулзалт хийлээ



МҮХАҮТ-ын Гүйцэтгэх захирал Ц.Магнайбаатараар ахлуулсан бизнес групп Канад улсын Монреал хотноо болж буй "SIAL Canada 2026" олон улсын хүнсний үзэсгэлэнд анх удаагаа оролцох үеэрээ тус хот дахь Өргөмжит консул Пол Лэмитэй уулзаж, хоёр орны бизнесийн түншлэлийг идэвхжүүлэх болон экспортын боломжуудыг дэмжих талаар санал солилцлоо.

Монгол-Канадын бизнесийн хамтын ажиллагааны шинэ гарцуудыг судаллаа



Монгол Улсаас Канад Улсад суугаа Элчин сайд Э.Сарантогос МҮХАҮТ-ын Гүйцэтгэх захирал Ц.Магнайбаатар тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзан, хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, уул уурхайн

бус экспортыг дэмжих болон технологи нутагшуулах чиглэлээр санал солилцсон бөгөөд МҮХАҮТ-ын зүгээс бизнес эрхлэгчдийг Хойд Америкийн зах зээлд гарахад нь ЭСЯ-тай хамтран бүх талын гүүр болон ажиллахаа илэрхийллээ.

МҮХАҮТ, Канадын TFO байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлнэ



МҮХАҮТ-ын Гүйцэтгэх захирал Ц.Магнайбаатар Канадын TFO байгууллагын Хөтөлбөрийн захирал Закиулла Муншитай уулзаж, хөгжиж буй орнуудын жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хурдасгах зорилготой тус байгууллагын туршлагад тулгуурлан Монгол Улсын экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг олон улсын зах зээлд нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллагааны талаар ярилцлаа.

Канад улсад үйл ажиллагаа явуулж буй "CASHMERE CASA" дэлгүүртэй танилцлаа



МҮХАҮТ-ын Гүйцэтгэх захирал Ц.Магнайбаатар тэргүүтэй төлөөлөгчид Канад улсын Оттава хотноо ажиллах үеэрээ Монголын үндэсний үйлдвэрлэгчдийн ноос, ноолууран бүтээгдэхүүнийг Хойд Америкийн зах зээлд сурталчлан борлуулж, хоёр улсын худалдааны хамтын ажиллагаанд бодит гүүр болон ажиллаж буй "Cashmere Casa" дэлгүүрийн үйл ажиллагаатай танилцлаа.

Монголын хүнс үйлдвэрлэгчид хойд Америкийн хамгийн том үзэсгэлэн "SIAL CANADA"-д оролцлоо

МҮХАҮТ-аас анх удаа үндэсний үйлдвэрлэгчдийн групп бүрдүүлэн Канад улсын Монреал хотноо болж буй, дэлхийн 55 орны 800 гаруй аж ахуйн нэгж болон 23,000 гаруй мэргэжилтнүүдийг нэг дор цуглуулдаг Хойд Америкийн хүнсний салбарын хамгийн том "SIAL Canada 2026" үзэсгэлэнд амжилттай оролцлоо.



Тус үзэсгэлэнд МҮХАҮТ-ын Гүйцэтгэх захирал Ц.Магнайбаатар, Үзэсгэлэн яармагийн газрын ахлах мэргэжилтэн Ц.Хулан нараар ахлуулсан Мон-Тува ХХК, Гантиг Мах ХХК, Амид Ложистик ХХК, Мандала Ай Юу ХХК, Номад Базар ХХК, Пума Сервис ХХК болон

Чингүүнбат ХХК-ийн төлөөлөгчид салбарын дэвшилтэт технологитой танилцаж, бараа бүтээгдэхүүнээ Хойд Америкийн зах зээлд гаргах боломжийг судаллаа.

МҮХАҮТ болон Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага хамтын ажиллагааны уулзалт хийлээ



МҮХАҮТ-ын удирдлагууд Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын төлөөлөгчидтэй уулзаж, нийлүүлэлтийн сүлжээ, ESG зарчим болон судалгааны салбарт хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэхээр тохиролцсон бөгөөд

энэ хүрээнд тус танхим Олон улсын ажил олгогчдын байгууллага (IOE)-д гишүүнээр элссэн нь Монголын ажил олгогчдын дуу хоолойг дэлхийн түвшинд хүргэх чухал алхам болсныг онцлов.



7 ХОНОГИЙН ТОЙМ

Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын тухай хуулийн шинэчлэл – бизнесийн орчинд юу өөрчлөгдөх вэ?



УИХ дахь Ардчилсан намын бүлгээс зохион байгуулсан “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай шинэчилсэн найруулга” хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлэгт хууль санаачлагчид болон ТББ, Мэргэжлийн холбоод болон бизнесийн салбарын 58 төлөөлөл оролцож, хуулийн шинэчлэлийн талаарх байр сууриа илэрхийллээ.



Chamber podcast шинэ дугаар

“Entrepreneur 2025” аялал жуулчлалын салбарын онцлох аж ахуйн нэгж, аялал жуулчлалын салбартаа өөрийн гэсэн өнгө төрхийг тодорхойлж буй

Жамоторабэрү ХХК-ийн амжилтын түүхийг Chamber Podcast-аас онцолж байна.

Хосмог сургалтыг танилцуулах, Төр-Хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх өдөрлөг амжилттай зохион байгуулагдлаа




“Орон нутагт хосмог сургалтыг хэрэгжүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийн тогтолцоог бэхжүүлэх” нээлттэй өдөрлөг, сургалт, семинар Орхон аймаг дахь Политехникийн коллеж, ШУТИС-ийн харьяа Хөвсгөл аймаг дахь политехник коллеж, Зүүнхараа Политехникийн коллежид амжилттай зохион байгуулагдлаа.

Экспорт, Гадаад Худалдааны Боломжууд” сэдэвт цахим сургалт зохион байгуулагдлаа

Тус сургалтад Дархан-Уул, Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй 40 гаруй аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөлөл, хувь хүмүүс оролцон мэдээлэл авч санал солилцов. Цаашид орон нутгийн бизнес эрхлэгчдэд Монгол Улсын нэгдэн орсон хоёр талт болон олон талт худалдааны хэлэлцээрүүд болон гадаад худалдааны чиглэлээр

сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах юм.



МҮХАҮТ-ААС УИХ-ЫН ШИЙДВЭРТ ХҮНДЭТГЭЛТЭЙ ХАНДАЖ БАЙГААГАА ИЛЭРХИЙЛЭХИЙН ЗЭРЭГЦЭЭ “ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ” ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ТАЛУУДЫН САНАЛЫГ ТУСГАН САЙЖРУУЛЖ, БОГИНО ХУГАЦААНД ДАХИН ӨРГӨН МЭДҮҮЛЭХЭД БЭЛЭН БАЙГААГАА МЭДЭГДЭЖ БАЙНА.



БИЗНЕС ФОРУМ БА ҮЗЭСГЭЛЭНГҮҮД



1. “Монгол-Чехийн бизнес уулзалт, аялал” /2026.05.12–20/ Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим Бүгд Найрамдах Чех Улсын Прага хотноо “Монгол-Чехийн бизнес уулзалт, аялал” арга хэмжээг зохион байгуулна.



2. Монгол-ОХУ-ын Эрхүү мужийн бизнес эрхлэгчидтэй хийх В2В уулзалтад /2026.05.19/ Эрхүү мужийн барилга, ноос ноолуур, банк санхүү, оёдол, даавуу үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд оролцоно.



3. Чанарын хяналт ба баталгаажуулалт (QA/QC) сургалт /2026.05.26–27/

3. Лабораторийн ажилтны ур чадварыг хөгжүүлэх сургалт №1

5. Шанхай руу тоног төхөөрөмжийн туршлага судлах аялал / 2026.05.12 – 05.16 / МҮХАҮТ-ын гишүүн байгууллагуудыг Шанхай хотын сэргээгдэх эрчим хүч, ногоон технологи, хүнс болон сүүний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч нартай танилцах, туршлага судлах, В2В уулзалт хийх бизнес аялалд урьж байна.



6. “Bazaar Berlin 2026” /11.04–08/: ХБНГУ-ын Берлин хотноо болох дэлхийн соёл, гар урлалын үзэсгэлэнд оролцохыг урьж байна.



7. KIDS EXPO 2026 /2026.05.29–06.01/ эх, үрсийн баярт зориулсан үзэсгэлэнд оролцогчдын бүртгэл явагдаж байна.



8. “Envex 2026” олон улсын үзэсгэлэнд урьж байна /2026.05.19–05.23/

Байгаль орчны технологи, ногоон эрчим хүчний салбарын хамгийн том цугларалт “ENVEX 2026” 47 дахь удаагийн үзэсгэлэн Сөүл хотноо зохион байгуулагдах гэж байна.